

НҮҮРСНИЙ ХУДАЛДАА БА ГААЛИЙН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГА

Н.Батнасан*, Л.Олонбаяр**, Н.Мөнхзүл***

Абстракт

Энэхүү өгцүллийг өнөөгийн нийгмийн хурц тулгамдсан асуудал болоод буй нүцрсний хулгайн нөхцөл байдлыг шинжилж, түүнийг дахин давтагдахаас сэргийлэх үнднээс хил, гааль, хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, уялдуулах арга замуудыг тодорхойлох зорилгоор бичив.

Түлхүүр үгс: *Нүцрсний хулгай, хил дамнасан худалдаа, хил гаалийн хяналт*

THE COAL TRADE AND NEEDS TO IMPROVE CUSTOMS CONTROL

Abstract

This article aims to analyze the situation of coal theft corruption, which has become a critical social problem today, and to determine ways to improve and coordinate the activities of the customs, border, and other inspection bodies to prevent it from happening again.

Keywords: The coal theft corruption, across border trade, customs and border control

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): batnasan@num.edu.mn

** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): olonbayar0208@gmail.com

*** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): zulaa_g16@yahoo.com

1. Нүүрсний худалдааны өнөөгийн нөхцөл байдалд хийсэн шинжилгээ

“Нүүрсний хулгай” эдүгээ Монголын улс төрийн тогтолцоог ганхуулсан томоохон үйл явдал болоод байна. Хулгай гарах болсон шалтгаан нөхцлийн талаар хүмүүсийн дунд таамаг шинжтэй олон зүйл яригдаж байгаа боловч манай улсын хил, гааль, хяналтын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо сул, хяналт шалгалт хийх арга барил хоцрогдсон нь энэхүү үйл явдлаар дамжин хурц тод илэрлээ.

УИХ-ын гишүүн Т.Доржханд 40 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний нүүрсний хулгай хийгдсэн хэмээн мэдээлж, хулгайг эсэргүүцсэн олон хоногийн жагсаал хөдөлгөөн эхэлж, нүүрсний хулгайн талаарх мэдээлэл олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдах болов.

ЗГХЭГ-ын дарга Д.Амарбаясгалан 2022 оны 12 сарын 13-ны өдөр мэдэгдэл хийж, “1995 оноос энэ оны 12 дугаар сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд 336.4 сая тонн нүүрс экспортлож, нийт дүнгээр нь авч үзвэл 45.2 их наяд төгрөгийн борлуулалт хийсэн байна.


Татвараас 10 их наяд төгрөгийг татан төвлөрүүлсэн ба УИХ-ын гишүүн Т.Доржхандын олон нийтэд цацсан мэдээлэл бодит байдалтай нийцэхгүй байна. Тодруулбал, үүнээс үзвэл нүүрсний 40 их наядын хулгай гарсан гэдэг нь худал мэдээлэл болохыг албан ёсоор мэдэгдье” гэсэн юм.

Бодит байдлыг харуулах үүднээс Олон улсын худалдааны төв (ITC Trade map 2022)-өөс гаргасан хөндлөнгийн тоо баримтад тулгуурлан болж өнгөрсөн үйл явдлын талаар судалж үзэхэд, нүүрсний хулгай барагцаалбал 2016 оны үеэс эхлэн явагдсан байх магадлалтай байна. Учир нь үүнээс өмнө хийгдэж байсан худалдаанд Монголын талаас экспортлосон нүүрс хэмжээний хувьд ямагт БНХАУ-ын импортын нүүрснээс бага байжээ. Нүүрсний тээвэрлэлтийг авто замаар, задгай тэвштэй тээврийн хэрэгслээр хийдэг байсан, багахан хэмжээний алдагдал гарч болох талтай тул энэхүү зөрүүг ямар нэгэн хэмжээгээр хүлээн зөвшөөрч болох талтай.

Харин 2016 оноос эхлэн Монголын талаас экспортлосон нүүрсний хэмжээ Хятадын талын импортлосон хэмжээ-нээс бүтэн 1.0 сая тн-оор давж эхэлснийг “нүүрсний хулгай”-аас өөр юугаар ч тайлбарлах боломжгүй юм.

2017 онд Монголын талын экспорт Хятадын импортоос 1.29 сая тн-оор давж гарсан бол 2018 онд 0.38 сая тн-оор, 2019 онд 0.26 сая тн-оор, 2020 онд 1.24 сая тн-оор, 2021 онд 1.47 сая тн-оор, нийтдээ 5.55 сая тн-оор давж гарчээ.²

² ITC Trade map 2022-т тулгуурлан зохиогчийн хийсэн тооцоо



Эх сурвалж: ИТС Trade map 2022

Олон жилийн дунджаар Монголын талаас экспортлосон нүүрсний хэмжээ Хятадын талын импортлосон дүнгээс 1.45%-иар дутуу байсан энэ нь тэвэрлэлтийн явцад гарсан алдагдал, хоёр талын хэмжүүрийн зөрүү зэрэгтэй холбоотой. 2016-2021 онуудад экспортлосон 170.53 сая тн нүүрснээс энэ жишгээр дутна гэж үзвэл 2.47 сая тн дутна. Үүнийг оролцуулан тооцвол, 2016-2021 онуудад нийтдээ 5.55-8.02 сая тн нүүрсийг хулгайгаар экспортлосон байх магадлалтай. Үүнийг тухайн үеийн худалдааны үнээр илэрхийлбэл, 340.34-491.79 сая ам.доллар, өнөөгийн ханшаар 1.2 – 1.7 орчим их наяд төгрөгийн хэмжээнд байна.³

Хүснэгт 1. Монгол - Хятадын хоорондох нүүрсний худалдааны үзүүлэлтүүд 2003-2021 онуудад

Үзүүлэлтүүд	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Монголын экспортын статистик																			
Үнийн дүн*	5.85	16.50	26.62	45.07	114.99	182.44	305.73	871.53	2246.04	1874.89	1116.11	847.18	532.31	949.16	2187.78	2754.55	3014.24	2008.79	2465.81
Тоо хэмжээ**	433.24	1634.51	2217.63	2348.73	3215.35	4083.89	7093.50	16497.28	21001.26	20520.07	18193.27	19461.34	14426.31	25317.32	32291.72	35360.69	35797.55	27209.90	14557.79
Нэгжийн үнэ***	13.49	10.10	12.00	19.19	35.76	44.67	43.10	52.83	106.95	91.37	61.35	43.53	36.90	37.49	67.75	77.90	84.20	73.83	169.38
Хятадын импортын статистик																			
Үнийн дүн*	2.11	12.25	29.83	41.36	99.50	242.57	317.10	1013.85	1594.58	1693.72	1186.71	945.98	535.53	994.34	2201.35	2819.45	3073.32	2002.25	2002.44
Тоо хэмжээ**	68.51	1601.19	2538.56	2352.22	3240.93	4043.93	6003.34	16594.78	20154.68	21731.25	17328.93	19226.46	14343.76	26315.74	33577.72	35737.54	36057.77	28450.02	16029.01
Нэгжийн үнэ***	30.84	7.65	11.75	17.58	30.70	59.98	52.82	61.09	79.12	77.94	68.48	49.20	37.34	37.79	65.56	78.89	83.23	70.38	124.97
БНХАУ-ын нийт импорт																			
Үнийн дүн*	363.41	891.81	1383.45	1617.79	2421.77	3569.80	10573.67	16921.99	20883.86	25295.09	25933.11	18904.30	10117.25	11486.30	18522.79	19586.19	18946.06	16411.78	27050.01
Тоо хэмжээ**	10545.46	18686.65	26171.00	38105.21	51015.89	40342.00	125834.39	164568.50	182054.13	234281.25	266732.36	226690.99	155924.86	183430.38	188278.78	186422.30	197054.02	204374.91	204111.48
Нэгжийн үнэ***	34.46	47.72	52.86	42.46	47.47	87.00	84.03	102.83	114.71	107.97	97.23	83.39	64.80	62.62	98.38	105.06	96.15	80.30	132.51

* - үнийн дүн сая ам.доллараар
 ** - тоо хэмжээ мянган тн
 *** - нэгжийн үнэ ам.доллараар

Эх сурвалж: ИТС Trade map 2022

³ ИТС Trade map 2022-т тулгуурлан зохиогчийн хийсэн тооцоо

Олон улсын худалдааны төвийн мэдээллийн санд оруулсан Монгол болон БНХАУ-ын нүүрсний экспорт, импортын мэдээ нь “Инкотермс”-ын DAF/DAT нөхцлүүдээр тусгагдсан. Иймд талууд нүүрсний гаалийн үнийг хэлцлийн аргаар тодорхойлсон нөхцөлд хоёр улсын статистикт тусгагдсан үнүүд маш ойролцоо буюу тэнцүү хэмжээнд байх ёстой. Гэвч Монголын талаас нүүрсийг худалдсан үнэ болон Хятадын худалдан авсан үнийн хооронд томоохон зөрүү байна. Тухайлбал, 2003-2021 онуудад талуудын хооронд 1183.8 сая ам.долларын үнийн зөрүү үүсчээ. / Хүснэгт №1-ээс тооцоолов/

Ийм зөрүү үүсэх хоёр үндсэн нөхцөл бий. Энэ нь нэгд, гаалийн үнийг тогтоохдоо ашигт малтмалын нөөц ашигласны татварыг нэмэгдүүлэх зорилгоор хэлцлийн үнийн аргаас өөр аргыг ашиглан татвар тооцох суурь үнийг өсгөсөнтэй холбоотой байж болно. Хоёрт, экспортлогч компаниуд орлогын татвараас зайлсхийхийн тулд хоёр гэрээг ашигласантай холбоотой байж болох юм. Иймд нүүрсний хулгайн асуудлыг шалгахдаа татвараас зугатах зорилгоор хоёр гэрээ ашигласан байж болох магадлалыг зайлшгүй нягтлан шалгах ёстой.

Нүүрсний худалдаанд үүссэн өөр нэг томоохон асуудал бол түүнийг хэт доогуур үнээр худалддаг явдал юм. Энэ нь нэгд, Монголын нүүрс экспортлогч олон компани ганц худалдан авагч дээр очиж, үнийг өрсөлдөн бууруулж худалдаалдагтай холбоотой байж талтай. Хоёрт, оптек гэрээний дагуу урьдчилгаа төлбөр авч, хямдаар худалдаалдагтай холбоотой байж болох юм. /График №2/ 2003-2021 оны хооронд Монголоос БНХАУ-д худалдаалсан нүүрсний үнэ, мөн хугацаанд тус улсын нүүрс импортлосон дундаж үнэ хоёрын хооронд 7700.0 сая ам.долларын зөрүү үүсчээ. Энэ нь өнөөгийн ханшаар тооцож үзэхэд 26.5 орчим их наяд төгрөгтэй тэнцэж байна.



Эх сурвалж: ИТС Trade map 2022

Хямд үнэд Хятадын нүүрсний гол зах зээлүүдээс алслагдсан байршил нөлөөлсөн байж болох талтай. Гэвч хямд үнээс үүдэлтэй алдагдлыг бууруулах асуудалд анхаарал хандуулах гарцаагүй шаардлага үүссэн болохыг дээрх тоо баримтууд харуулж байна.

2. Худалдаа эрхлэх орчин нөхцөл, хил, гаалийн хяналт

Улс орнуудын худалдаа, бизнесийн орчны талаар бодитой бөгөөд бүрэн хэмжээний мэдээлэл өгдөг эх үүсвэрүүдийн нэг нь Дэлхийн банкнаас 2003 оноос эхлэн эрхлэн гаргаж буй “Doing business” илтгэл юм.

Уг илтгэлд улс орнуудад бизнес эрхлэх орчин нөхцлийг бизнесээ эхлэх, барилгын зөвшөөрөл авах, эрчим хүчээр хангагдах, өмчөө бүртгүүлэх, зээл авах, жижиг хувьцаатай хөрөнгө оруулагчийн эрхээ хамгаалуулах зэрэг боломжууд, татвар төлөх, улс хооронд худалдаа эрхлэх, гэрээг хэрэгжүүлэх, маргаан шийдвэрлэх орчин нөхцөл зэрэг үзүүлэлтүүдээр үнэлж, тэдгээрийг нэгтгэн дүгнэж, индексжүүлэн, олон улсын хэмжээнд улс орон бүрийн бизнес эрхлэх орчин нөхцлийг харьцуулан үнэлж дүгнэдэг.

Дэлхийн банкнаас хамгийн сүүлд гаргасан “Doing business – 2020” илтгэлд дурдсанаар Монгол улс нь бизнес эрхлэхэд амар хялбар байдлаараа дэлхийн 190 орноос 81-р байрт оржээ. Энэ нь өмнөх 2018 оны үзүүлэлт болох 74-р байраас 7 байр ухарсан хэрэг юм. Харин “Өв уламжлалын сан” (Heritage Foundation)-аас гаргасан эдийн засгийн эрх чөлөөний индексээр дэлхийн 178 орноос 86-р байрт эрэмбэлэгдэв.

Хамгийн сүүлд гаргасан тайланд бизнес эрхлэх орчныг тодорхойлох үзүүлэлт бүрийн хувьд Монгол улсын эзлэх байр суурь харилцан адилгүй хэмжээнд байна. Зээл авах, жижиг хөрөнгө оруулагчийг хамгаалах, барилгын зөвшөөрөл авахтай холбоотой үзүүлтээр харьцангуй дээгүүр байруудыг эзэлж байгаа бол эрчим хүчээр хангагдах боломж, улс хооронд худалдаа эрхлэх, маргаан шийдвэрлэх зэрэг үзүүлэлтүүдээр харьцангуй хойгуур байранд байна. (Хүснэгт N° 2)

Хүснэгт 2. Монгол улсын бизнес эрхлэх орчны үндсэн гол үзүүлэлтүүд


№	Үзүүлэлт	Оноо / 100 онооноос	Байр /190 орноос
1.	Бизнесээ эхлэх	86.7	100
2.	Барилгын зөвшөөрөл авах	78.2	29
3.	Эрчим хүчээр хангагдах боломж	55.0	152
4.	Өмчөө бүртгүүлэх	74.2	50

5.	Зээл авах боломж	80.0	25
6.	Жижиг хувьцаатай хөрөнгө оруулагчийг хамгаалах	74.0	25
7.	Татвар төлөх	77.3	71
8.	Улс хооронд худалдаа эрхлэх	60.8	143
9.	Гэрээг хэрэгжүүлэх	61.4	75
10.	Маргаан шийдвэрлэх	30.1	150

Эх сурвалж: *Doing business 2020*

Дэлхийн банкны илтгэлээс үзэхэд 2019 онд Монгол улс нь бизнес эрхлэх орчин нөхцлөөр худалдааны гол түнш орнууд болох БНХАУ, Япон, БНСУ, Швейцарь зэрэг орнуудаас хойгуур байрыг эзэлж байгаа боловч ОХУ-аас дээгүүр байранд эрэмбэлэгджээ. (График №3)

График 3. Монгол улсын худалдааны гол түнш орнуудын бизнес эрхлэх орчны үзүүлэлтүүд



Эх сурвалж: *Doing business 2020*

Улс хоорондын худалдаа эрхлэхэд зарцуулж буй цаг хугацаа, зардлын үзүүлэлтүүд бүс нутгийн болон өндөр хөгжилтэй орнуудынхаас үлэмж өндөр хэмжээнд байна.

Тухайлбал, экспортын хилийн хяналтад зарцуулах хугацаа бүс нутгийнхаас 2.3 дахин, өндөр хөгжилтэй ЭЗХХАБ-ын гишүүн орнуудынхаас 10.5 дахин их, экспортын бичиг баримтыг бүрдүүлэхэд зарцуулах хугацаа бүс нутгийн орнуудынхаас 3.0 дахин, өндөр хөгжилтэй орнуудынхаас 73.0 дахин их байна. Түүнчлэн импортын хилийн хяналтад зарцуулах хугацаа өндөр хөгжилтэй орнуудынхаас 5.6 дахин, импортын бичиг баримт бүрдүүлэхэд зарцуулах

хугацаа бүс нутгийн орнуудынхаас 2.1 дахин, өндөр хөгжилтэй орнуудынхаас 33.8 дахин их байна. Харин экспорт, импортын хилийн хяналт хийх болон бичиг баримтыг бүрдүүлэхэд зарцуулах зардлын хэмжээ бүс нутгийн орнуудынхаас бага байгаа боловч өндөр хөгжилтэй орнуудынхаас 1.6-3.5 дахин өндөр хэмжээнд байна. (Хүснэгт №3)

Хүснэгт 4. Экспорт, импортын хилийн хяналт хийх болон бичиг баримтыг бүрдүүлэхэд зарцуулах хугацаа ба зардал

№	Үзүүлэлт	Зарцуулах хугацаа / цагаар			Зарцуулах зардал / ам.доллараар		
		Монгол	Ази, Номхон далайн бүс нутаг	ЭЗХАХБ-ын гишүүн өндөр орлоготой орнууд	Монгол	Ази, Номхон далайн бүс нутаг	ЭЗХАХБ-ын гишүүн өндөр орлоготой орнууд
1	Экспортын хилийн хяналт	134	57.5	12.7	225	381.1	136.8
2	Экспортын бичиг баримт	168	55.6	2.3	64	109.4	33.4
3	Импортын хилийн хяналт	48	68.4	8.5	210	422.8	98.1
4	Импортын бичиг баримт	115	53.7	3.4	83	108.4	23.5

Эх сурвалж: Doing business 2020

2019 оны байдлаар экспортын хилийн хяналтад зарцуулж буй нийт хугацаа 134 цаг байсан ба үүнээс 32 цагийг гаалийн хяналт шалгалт хийлгэхэд, 72 цагийг бусад хяналтын байгууллагуудаар хяналт хийлгэхэд, 30 цагийг барааг ачиж буулгах, шилжүүлэн ачихад тус тус зарцуулжээ. Экспортын хилийн хяналтыг хийлгэхэд нийт 225 ам.доллар зарцуулсан бөгөөд үүнээс 41.1 ам.долларыг гаалийн бүрдүүлэлт ба хяналт шалгалтад, 34.0 ам.долларыг мэргэжлийн болон хилийн байгуулагуудын хяналт шалгалтад, 150 ам.долларыг хил дээр ачиж буулгах, шилжүүлэн ачихад тус тус зарцуулсан.

Дэлхийн банкны дээрх илтгэлээс үзэхэд, импортын бараа хил нэвтрэхэд 48 цагийг зарцуулж байна. Үүнээс 24 цагийг гаалийн хяналт шалгалт хийлгэхэд, 24 цагийг хил дээр ачиж буулгах, шилжүүлэн ачихад тус тус зарцуулдаг. Импортын бараа хил нэвтрэхэд 210.0 ам.доллар зарцуулж байгаагаас 59.8 ам.долларыг гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалтад, 150 ам.долларыг хил дээр ачиж буулгах, шилжүүлэн ачихад зарцуулж байв.

Ийнхүү Монгол улсад хил, гаалийн хяналтыг хийхэд зарцуулж буй цаг хугацаа өндөр байгаагийн зэрэгцээ хамгийн гол нь хяналт шалгалт үр дүн муутай явагддагийг нүүрсний хулгайн хэрэг явдал тод томруунаар харууллаа.

“Doing business – 2020” илтгэлд дурдсанаар олон улс орон гаалиас шаарддаг мэдээллийг цахимаар мэдүүлэх, боловсруулах, цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан хяналт хийх, бүс нутгийн хэмжээнд улс хоорондын гаалийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, худалдааны логистикийн дэд бүтцээ сайжруулах, бүтээгдэхүүн бүрийн онцлогт нийцсэн хяналт шалгалт хийх, гаалийн харилцаанд оролцогч талууддаа зориулан сургалт зохион байгуулах, тэдэнтэй өргөн хүрээнд хамтран ажиллах зэргээр хил, гаалийн хяналтыг үр дүнтэй явуулах арга техникүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.

Монгол улсын хил, гаалийн хяналтын байгууллагууд цахим мэдээллийн системд холбогдсон, эрсдэлд суурилсан удирдлагыг нэвтрүүлсэн гэж мэдэгддэг. Тэгвэл эндээс авч хэрэгжүүлсэн эдгээр арга хэмжээ нь бодит үр дүнг яагаад үзүүлэхгүй байна вэ? Монголд хил, гаалийн хяналт шалгалт яагаад үр дүнтэй явагддаггүй вэ, түүнийг цаашид хэрхэн сайжруулах вэ гэсэн асуудлууд зүй ёсоор урган гарна.

3. Хил, гаалийн хяналт шалгалтыг сайжруулах арга зам

Монгол улсын Гаалийн Ерөнхий Газар худалдааг хөнгөвчлөх, хил, гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор дор дурдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

- Гаалийн байгууллагын эрхзүйн орчныг боловсронгуй болгох
- Гаалийн мэдээллийн автоматжуулсан системийг нэвтрүүлэх, газар хороодыг мэдээллийн нэгдсэн системд холбох
- Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг нэвтрүүлэх, “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж” хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэх, тээврийн хэрэгслийн хил нэвтрэх хугацааг түргэн шуурхай болгох
- Хяналт шалгалтад ашиглах тоног төхөөрөмжийг шинэчлэх, гаалийн лабораторийг иж бүрэн шинэчлэх
- Гаалийн байгууллагын гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, гааль-бизнесийн түншлэлийг бэхжүүлэх,
- Ажилтнуудыг сургаж бэлтгэх, мэдлэг ур чадварыг нь дээшлүүлэх

Гаалийн байгууллагаас хэрэгжүүлсэн эдгээр арга хэмжээ нь худалдааг хөнгөвчлөх, гаалийн хяналт, шалгалтыг сайжруулах чиглэлд ахиц дэвшлийг авч ирж байгаа боловч засч залруулах, нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай зүйлс цөөнгүй байгаа юм.

Эн түрүүнд авч үзвэл зохих зүйл бол “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж” хөтөлбөрт суурилсан эрсдлийн удирдлагын өнөөгийн тогтолцоо. Орчин үед эрсдэлд суурилсан хяналт шалгалт нь бизнесийг “итгэмжлэгдсэн” буюу “итгэмжлэгдээгүй” гэж ангилах зарчмаар бус харин хилээр нэвтэрч буй бараа, тээврийн хэрэгсэл, зорчигч бүрийн эрсдлийг тооцож үзсэний үндсэн дээр хяналт, шалгалтыг явуулах зарчимд суурилдаг.

Эрсдэлд суурилсан гаалийн хяналт шалгалтыг нэвтрүүлэхэд эрсдлийн түүхэн мэдээлэл агуулсан гаалийн мэдээллийн сан чухал ач холбогдолтой. Монгол улсын гаалийн байгууллага НҮБ-ын Худалдаа, хөгжлийн байгууллагын техникийн туслалцаатайгаар 1993-2003 онуудад гаалийн удирдлагын ASYCUDA автоматжуулсан системийг, 2003-2010 онуудад Азийн хөгжлийн банкны техникийн туслалцаатайгаар GAMAS системийг, 2010 оноос хойш гаалийн удирдлагын автоматжуулсан систем CAIS болон гаалийн гадаад мэдээллийн портал CEPS-ийг гаалийн удирдлагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Харамсалтай нь эдгээр системүүдэд байгаа статистикийн болон эрсдлийн түүхэн мэдээллийг нэгтгээгүй. Нөгөөтэйгүүр татвар, цагдаа, АТГ, прокурор, шүүхийн байгууллагууд дээр байгаа гаалийн хууль тогтоомжийг зөрчсөн мэдээллийг ч нэгдсэн системд оруулж, бүртгэж чадаагүй байна. Энэ бүхнээс шалтгаалан гаалийн эрсдлийн төлвийг тооцох загваруудыг хөгжүүлэх, ашиглах боломж хязгаарлагдмал байгаа юм.

2015 онд боловсруулсан гаалийн хяналтын төлвийг тодорхойлох загвар⁴-ыг өнөөдрийг хүртэл нэвтрүүлээгүйгээс хил нэвтэрч буй барааны дийлэнх хэсгийг улаан, улбар шар төлөвт оруулан шалгаж, асар их хэмжээний хүч хөдөлмөр, хөрөнгө, цаг хугацааг үр ашиггүй зарцуулж байна. Бараа, тээврийн хэрэгсэл хил нэвтрэх үед түүний эрсдлийн төлөвийг урьдчилан тодорхойлж чадахгүй байгаа нь ийм үр дагаварыг бий болгож байгаа юм.

Өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас үзэхэд, хилээр нэвтэрч буй барааны хяналтын төлөвийг урьдчилан тодорхойлохын тулд импортлох барааны хувьд ачилт хийгдмэгц тухайн барааны тээврийн болон бусад бичиг баримтуудыг электрон хэлбэрээр урьдчилан авч, барааг хил нэвтрэх хүртэл хяналтын төлөвийг нь урьдчилан тодорхойлж байна. Харин экспортын барааны хувьд экспортлогч ачилтаас тодорхой хугацааны өмнө бараагаа цахим хэлбэрээр гаальд мэдүүлдэг бөгөөд бараа ачигдаж, гаалийн хяналт шалгалтад орох хүртэлх хугацаанд түүний хяналтын төлөвийг урьдчилан тодорхойлдог.

Монгол улс 2016 онд НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг нийгмийн

⁴ Tsendsuren Davaa, Batnasan Namsrai “Ways to modernize customs risk management in Mongolia” International Network of Customs Universities pre World Customs Organization & Charles Sturt University, Australia “World Customs Journal” p 24-37, Volume 9, Number 2, September 2015

комиссын ивээл дор байгуулсан “Цаасгүй худалдааны хэлэлцээр”-т нэгдэн орсон боловч эдүгээг хүртэл цаасгүй худалдааг нэвтрүүлэх талаар дорвитой алхам хийж чадаагүй. Энэ нь хилээр орж ирж буй импортын барааны хяналтын төлөвийг урьдчилан тоодорхойлох боломжийг олгохгүй байгаа юм. Нөгөөтэйгүүр хилээр гарч буй барааны ачилтын баримтыг импортлогч оронд цахимаар хүргүүлж чадахгүй байгаагаас манай бараа таваар гадаадын улс орны хилийн боомтуудаар нэвтрэхэд харьцангуй урт хугацааг зарцуулахад хүргэж байна.

Экспортлогч, импортлогч байгууллагууд гаалийн мэдээллийн системд өөрөө урьдчилан мэдүүлдэг тогтолцоонд шилжих нь гаалийн эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэхэд чухал ач холбогдолтой. Гэвч эдүгээ ихэнх байгууллага гаалийн зуучлагч байгууллагаар дамжуулан мэдүүлж байгаа нь эдийн засгийн хувьд үр ашиггүй хэлбэр мөн юм.

Гаалийн хууль тогтоомжийг ДХБ-ын хэлэлцээрт нийцүүлэн өөрчлөх нь эрсдэлд суурилсан хяналтыг бий болгоход чухал ач холбогдолтой. Энэ хүрээнд ялангуяа гаалийн үнэлгээний арга аргачлал, бүрдүүлэлтийн горимуудыг хэлэлцээрт нийцүүлэн өөрчлөх нь цаашид аж ахуйн нэгж өөрөө мэдүүлдэг тогтолцоо руу шилжихэд чухал түлхэц өгөх болно.

Экспортын гаалийн үнэлгээнд ашиглаж буй аргачлалууд нь түнш орнуудтай хийж буй худалдааны статистик мэдээлэлд зөрүү үүсгэх, мэдээллийг харьцуулан жиших боломжгүй болгож байгаагийн зэрэгцээ төөрөгдүүлсэн мэдээлэл нь бодит нөхцөл байдлыг зөв үнэлэх, нөхцөлд байдалд тохирсон бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж буйд дүгнэлт хийж, засч залруулах нь зүйтэй болов уу.

Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад худалдааны үр ашгийг дээшлүүлэх, нээлттэй ил тод худалдааг явуулах зорилгоор Засгийн газрын 2022 оны 12 сарын 14-ний хуралдаанаар “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ыг баталж, мөн оны 12 сарын 15-ны өдрийн УИХ-ын чуулганы үдээс хойшхи нэгдсэн хуралдаанаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийн хийсэн. Цахим платформд суурилсан уул уурхайн бүтээгдэхүүний биржийг зөв ажиллуулж чадсан нөхцөлд олон худалдан авагч худалдаанд оролцох нөхцөл бүрдэж, бараа түүхий эдийг илүү үнэ хүргэж, үр ашигтай байдлаар худалдаалах боломж бүрдэнэ. Гэхдээ цахим арилжаанд худалдан авагчид оролцохгүй байх, ганц буюу эсвэл үгсэн хуйвалдсан цөөн худалдан авагч оролцох эрсдэл ч байгааг орхигдуулж болохгүй.

Цахим платформд суурилсан уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулах

дээрх арга хэмжээ нь хил, гаалийн хяналт шалгалтыг сайжруулах, түүхий эдийн хулгайтай тэмцэхэд нөлөө үзүүлж чадахгүй. Учир нь зөвхөн биржээр худалдаалсан түүхий эдийг хилээр нэвтрүүлэх, бусдыг хориглох эрх манай элсэн орсон ДХБ-ын гэрээ хэлэлцээрээр хязгаарлагдаж буй.

Нүүрсний хулгайтай тэмцэх, хил гаалийн хяналт шалгалтыг үр дүнтэй болгох хамгийн чухал арга нь цаасгүй худалдааны хэлэлцээрийг хэрэгжүүлж, худалдааны түнш орнуудтайгаа орж гарч буй бараа, тээврийн хэрэгслийн мэдээллийг байнга солилцож, мэдээллээ нээлттэй ил тод болгох явдал юм.

Ингэснээр эрсдэлд суурилсан гаалийн хяналт шалгалтыг бий болгох, худалдааг хөнгөвчлөх, хил гаалийн хяналт шалгалтыг хялбаршуулж, цаг хугацаа, зардал мөнгө хэмнэх асар өргөн боломж үүснэ.

Дүгнэлт

Хил, гаалийн хяналт шалгалтыг сайжруулах нь улс орны хөгжлийн амин чухал асуудлууд болохыг сүүлийн үеийн үйл явдлууд харуулж байна. Хяналт шалгалтыг сайжруулахад зарцуулах хөрөнгө оруулалт цаашдын болзошгүй том эрсдлүүдтэй харьцуулахад өчүүхэн бага болохыг статистик тоо баримтууд харуулж байна.

Хил гаалийн хяналт шалгалтыг сайжруулахын тулд хууль эрхзүй, мэдээллийн систем, удирдлага, бүтэц зохион байгуулалт, хяналтын арга технологи, ажилтнуудын мэдлэг ур чадварыг бүрэн хэмжээгээр хамарсан эрс шинэчлэл чухал болохыг дээр өгүүлсэн баримтууд харуулж байна.

Хамгийн гол нь олон улсын хэмжээнд нэгэнт нэвтэрчихсэн хяналтын арга технологийг элдэв засвар өөрчлөлтгүйгээр авч ашиглах чухал юм. Яльгүй мэт жижиг өөрчлөлт хяналт шалгалтын арга технологийг хэлбэрийн хувьд ижил мэт харагдуулж болох талтай ч агуулгын хувьд огт өөр тул өөр үр дүнд хүргэж болохыг манай гаалийн практик нотолж байна.

Мэдээллийн нэгдсэн тогтолцоо, эрсдэлд суурилсан хяналт шалгалт, цаасгүй худалдаа, цахим нэг цонх, худалдаанд оролцогч өөрөө мэдүүлэх боломж зэрэг нь орчин үеийн гаалийн үйл ажиллагааны хамгийн чухал хэсгүүд тул эдгээрийг олон улсын нийтлэг жишгийн дагуу хөгжүүлэх асуудалд анхаарах нь чухал болно.

Ашигласан материал:

ITC (2022)., “Trade map”

Laporte, Bertrand (2011)., “*Risk management system: using data mining*”

- in developing countries' customs administrations*", "World Customs Journal", pp. 17-27., Volume 5, Number 2.
- Davaa, Tsendsuren., Namsrai, Batnasan (2015)., "Ways to modernize customs risk management in Mongolia" "World Customs Journal" p 24-37, Volume 9, Number 2.
- WCO (2011)., "Customs Risk Management Compendium".
- Widdowson, D (2005)., 'Managing risk in the customs context', in L De Wulf & JB Sokol (eds), *Customs modernization handbook*, World Bank, Washington, DC.
- World Bank (2020)., *Doing business: trading across borders*, World Bank, Washington, DC.
- World Customs Organization (2000)., *Kyoto Convention General Annex*, Chapter 6, 'Guidelines on Customs Control', WCO, Brussels.
- World Customs Organization (2010)., 'Background paper on risk management', World Customs Organization Risk Management Forum, 28-29 June 2010, WCO, Brussels.
- Цэндсүрэн, Д., Батнасан, Н (2019)., "Гаалийн эрсдлийн удирдлага" УБ.